

**ИСОНО ФУДЗИКО «МОНГОРУ КАКУМЭЙ»  
(МОНГОЛЫН ХУВЬСГАЛ) ТЮО КОРОНСЯ  
ХЭВЛЭЛИЙН ГАЗАР. ТОКИО. 1974**

(Шүүмж)

Монгол ардын хувьсгал нь манай ард түмний олон зуун жилийн түүхэнд гарсан үндсэн эргэлт юм. Дорно дахины хамгийн хоцрогдсон орны нэг байсан монгол орон феодалын нийгмээс капитализмыг алгасан социализмд шилжих гэрэлт замыг нээж өгсөн 1921 оны хувьсгал нь дотоод гадаадын олон эрдэмтдийн анхаарлыг татсаар ирсэн нь зүйн хэрэг юм. Тэдний нэг нь японы монгол судлаач Исоно Фудзико юм. «Монголд хувьсгал гарсан юм уу? Хэрэв гарсан бол дэлхийн хоёр дугаар дайны дараа байх» гэж асуудаг хүмүүс цөөнгүй байдгийг зохиогч тэмдэглээд японы уншигч нарт Монголын хувьсгалын түүхийг танилцуулах зорилгоор дээрх нэг сэдэвт зохиолоо бичжээ. Монгол ардын хувьсгалын түүхийг бичихийн тулд Монгол орны байдлыг Хятад, Орос, Японы тухайн үеийн түүхтэй нягт холбон үзэх, хувьсгалын шинж чанарыг тодорхойлохын тулд «пролетари үгүй оронд социалист хувьсгал ялуулж», «капитализмыг алгасан социализмд шилжиж» чадсан монгол орны газарзүй, түүх, эдийн засгийн онцлогийг судлах хэрэгтэй гэж зохиогч үзжээ.

Монголын хувьсгалыг түүхийн өргөн дэвсгэр дээр харуулах зорилгоор Ф. Исоно зохиолынхоо нийт 7 бүлгийн удиртгал бүлгийг Юань гүрний мөхөхөөс Чин улсын эцэс хүртэлх Монгол оронд зориулжээ. Тус бүлгийг бичихдээ зохиогч Монголын түүх судлалын сүүлийн ололтыг тусгасан «БНМАУ-ын түүхийн» хоёрдугаар боть, (УБ., 1968) академич Ш. Нацагдоржийн «Халхын түүх» (УБ, 1963) зохиолуудыг ашиглажээ. Гэвч монголын хувьсгалын түүхийн он цагийн хүрээг бараг шаардлагагүй шахам сүрхий алсаас авч тэр үеийн үйл явдалтай хэт зууралдаад зарим хайш яйш дүгнэлт хийсэн тал байна. Зохиолынхоо 1, 2-р бүлэгт Монголын тусгаар тогтнолыг тунхагласан үйл явц, Богд хаант Монгол улсын гадаад, дотоод байдлын тухай зохиогч өгүүлээд 1906 оноос эхлэн Монголын талаар явуулж ирсэн Манж Чин улсын шинэ засгийн бодлого нь тусгаар тогтнолоо тунхаглах гол шалтгаан болсон мэт үзжээ. (28-р тал) Ийм дүгнэлт хийхийн хамт XIX зууны сүүл үеэс Монгол орон олон улсын капиталист зах зээлд татагдан орж ирснийг орхигдуулан, 1911 оны хятадын хувьсгалын нөлөөний тухай хэлсэн мөртлөө гадаад чухал хүчин зүйл болох 1905 оны Оросын хувьсгалын нөлөөг дурдсангүй (40-р тал). Түүнээс гадна зохиогч ард ангийн тэмцлийг цухас дурдан монголын дээд ангийн хар, шар феодалуудаас тус орны биеэ даасан байдлыг сэргээж ард олныг дангаар ноёрхон мөлжихийг эрмэлзэхдээ Бээжин рүү шинэ засгийн бодлогыг эсэргүүцэн илгээлт явуулж байсныг хэт дөвийлгөн үзүүлжээ (31, 32-р тал). Гэтэл үнэн хэрэг дээрээ 1911 оны эрх чөлөөний хөдөлгөөний шийдвэрлэгч хүчин болох ард түмэн 1905 оны Оросын хувьсгалын нөлөөгөөр идэвхжин үндэсний ба нийгмийн дарлалын эсрэг тэмцэж монго-

лын төр улсыг сэргээн байгуулахад хүргэсэн юм. Зохиогч Богд хаант Монгол улсын тухай өгүүлэхдээ «Хэдийгээр Хиагтын гэрээ ёсоор тусгаар тогтносон Монгол улс байгуулах оролдлого нурсан боловч Хятадад цэргийн бүлэглэл хоорондоо тэмцэлдэн тогтвортой төв засгийн газар үгүй, мөн Хятадаас Монголын хэрэгт оролцохыг Орос эсэргүүцэж байсан зэргээс үзэхэд Богдын засгийн газар дотоод хэрэгтээ тусгаар тогтносон улсын байр суурьтай байсан гэж хэлж болох юм» хэмээн дүгнэжээ. (80—81-р тал)

Богд хаант Монгол улсын дотоод байдлыг авч үзэхдээ Хужирбулангийн цэргийн зохион байгуулалттай эсэргүүцлийн анхны хэлбэр нь хувьсгалт тэмцлийн чухал сургууль болсныг тэмдэглэсэн (87-р тал) мөртлөө нэг талаас ардууд нөгөө талаас феодалууд болон гадаадын колоничлогчдын хоорондын үндсэн эсрэг тэсрэг тэмцлийг цухас дурдан том хар шар феодалуудын хоорондын зөрчлийг голчлон харуулжээ. Гэтэл монголын ард түмний тэмцэл үндсэн утга агуулгаараа феодализм ба империализмыг эсэргүүцсэн чанартай байсныг тодорхойлж өгсөнгүй.

Зохиогч, 3, 4-р бүлэгтээ 1919 онд хятадын булаан эзлэгчид түрэмгийлэн орсноос хойш 1921 онд ардын журамт цэрэг байгуулагдах үеийг хамарчээ. Хүрээнд хувьсгалт нууц бүлгүүд үүсч түүний цаашдын үйл ажиллагааны хөгжилд Хүрээнд байсан оросын хувьсгалчид болон Коминтерноос үзүүлсэн нөлөөг тэмдэглэсэн боловч (111—112-р тал) ер нь Монголын ард түмний хувьсгалт тэмцлийн өрнөлтөд Октябрийн аугаа их хувьсгалын үзүүлсэн асар их нөлөөг тодорхой гаргаагүй байна.

1920 оны сүүлчээр Монголд цөмрөн орсон генерал Унгернаар толгойлуулсан Оросын цагаан цэрэг, Япон улсын холбоог зохиогч товч авч үзжээ. Японы ГЯЯ-ны архивт үлдсэн Унгернтэй холбоотой цөөн хэдэн баримтаас үзэхэд Унгерний цэрэгт 50-иад япон хүн явсан болохыг тэмдэглээд тэд ямарваа нэг чиг байхгүй, хувийн эрх ашиг хөөцөлдөн түүний цэрэгт орсон байх гэж Исоно үзжээ. (131-р тал) Гэтэл тэдний яриагаар Унгернд байн байн «Японы армитай тохирсон ёсоор Японы засгийн газар туслана» гэж хэлдэг байсан ба тэднийг Читад байх үед японы ахмад Куроки Унгерний цэргийн ерөнхий командлагч болно гэсэн яриа сонсогдож байжээ. (131-р тал) Мөн Унгерн болон Манжуур хотын тагнуулын тусгай албаны хошууч Ёда нар 1921 оны 6-р сараас 7-р сар хүртэл захидлаар харилцаж байжээ. (131-р тал)

Эдгээр баримтад тулгуурлан дүгнэхдээ Японы засгийн газрын зүгээс Япон болон Унгерний харилцааг хэдийгээр эцсээ тултал үгүйсгэж байсан боловч Японы цэргийн хувьд хэрэв Унгерний санаархал хэрэгжвэл түүнийг ашиглан Сибирьт алдсан байр сууриа нөхөх бодол байгаагүй гэх газаргүй (131—132-р тал) гэж зохиогч үзсэн нь оновчтой болжээ.

Монгол ардын журамт цэрэг байгуулагдсан түүхэн үйл явцыг «Монгол ардын журамт цэргийн дурдатгалууд» 2 боть номтой танилцсаны үндсэн дээр нарийвчлан судалжээ. Энэ нь монголын хувьсгал монголчуудын гараар мандсан юм гэдгийг гэрчилж байна гэсэн дүгнэлтэд зохиогчийг хүргэжээ (150-р тал).

Монгол ардын хувьсгалт цэрэг Хиагтыг гамин цэргээс чөлөөлсний дараа Унгернтэй сүлбэлдсэн дотоодын харгис хүчний эсрэг хувьсгалт тэмцэл улам өрнөж 1921 оны 3-р сарын 15-наас 1922 оны 1-р сар хүртэл буюу Баруун хязгаарыг тохинуулж дуусах хүртэл үргэлжилсэн гэж Ф. Исоно 5-р бүлэгтээ авч үзжээ. Байлдан олсон хувьсгалын ялалтыг бэхжүүлэхээр ардын засгийн газраас авч явуулсан ний-

гэм эдийн засгийн чухал арга хэмжээнүүдийг зохиогч 6-р бүлэгт өнгөц авч үзээд Монгол орны хөгжлийн цаашдын замын талаар намын дотор гарсан хагарлыг голчлон анхаарсан тал харагдаж байна.

1924 онд хуралдсан МАХН-ын III их хурлаас капиталист биш хөгжлийн замыг сонгосон, Улсын анхдугаар их хурлаар Бүгд Найрамдах Улсаа тунхагласан, Монгол орон өнөөдөр социалист лагерийн бүрэн эрхт гишүүн болж, олон улсын тавцан дээр нэр хүнд нь дээшилсээр байгааг зохиогч зөв зүйтэй тэмдэглэсэн байна.

Ф. Исоногийн номд дээр дурдсан зарим дутагдал ажиглагдаж байгаа боловч БНМАУ-ын түүхчдийн бүтээлийг ашиглан Монгол дахь 1921 оны ардын хувьсгалын сэдвээр Японд хэвлэгдсэн энэхүү зохиол нь японы өргөн олон уншигчдыг Монгол орны хөгжил дэвшлийн эх үндсийг тавьж өгсөн Ардын хувьсгалын түүхтэй танилцуулах, цаашилбал, хоёр орны ард түмэн бие биеийнхээ түүх, соёлтой танилцах явдалд багагүй нэмэр хандив болох бүтээл болсныг тэмдэглэх нь зүйтэй юм.

**Ц. Батбаяр**